



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 465

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын хүүхэлдэйн театрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны ертгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 15,873,000.00 (арван таван сая найман зуун далан гурван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг худалдах хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Улсын хүүхэлдэйн театрын захирлын үүрэг гүйцэтгэгч М.Отгончимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002351

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн
465 дугаар тогтоолын хавсралт



Улсын хүүхэлдэйн театрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж, данснаас хасах
автомашинны жагсаалт

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан		Үлдэгдэл өртөг	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ
					үлдэгдэл	/төгрөг/		
1	ММС Роса, УБВ 73-91, автобус, арал: BE434F-04165	1988/2007	120,569	12,210,000.00	12,210,000.00	-	400,000.00	
2	Мада Бонго, УБӨ 02-57, ачааны автомашин, арал: SEF80418473	1993/2007	180,000	3,663,000.00	3,663,000.00	-	200,000.00	
				15,873,000.00	15,873,000.00	-		
Нийт дүн				(арван таван сая найман зуун далан гурван мянган)			(зургаан зуун мянган)	